

Казахстан улсын угсаатны шилжилт хөдөлгөөний бодлого, түүний үр дүн

Шугатайн Амангүл

*Эрдэм шинжилгээний ажилтан, магистр
ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс
Цахим хаяг: amangulsh@mas.ac.mn*

Хураангуй: 1991 онд Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ) задарч, Бүгд Найрамдах Казахстан Улс (БНКаЗУ) байгуулагдсаны дараа тус улсад хүн амын “олон улсын шилжилт хөдөлгөөн”-ий урсгал эрчимтэй явагдаж эхэлсэн билээ. Шинээр тусгаар тогтносон БНКаЗУ хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих, нийт хүн амд казах угсаатны эзлэх хэмжээг нэмэгдүүлэх замаар угсаатны бүтцээ өөрчлөх, нийгэм эдийн засгийн хөгжилтэй уялдуулан хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд дэлхийн өнцөг булан бүрээс казах угсаатнуудыг өөрсдийн “түүхэн эх нутаг” (historical homeland) болох БНКаЗУ-д шилжин ирж суурьших уриа дуудлага болгож, хүн амын шилжилт хөдөлгөөний тусгай бодлогыг хэрэгжүүлсэн. Ингэснээр БНКаЗУ-ыг чиглэсэн казах үндэстний хил дамнасан шилжилт хөдөлгөөн бүс нутгийн ба дэлхийн хэмжээнд эрчимтэй өрнөж, өнөөдрийг хүртэл тасралтгүй үргэлжилж байна. Энэхүү өгүүлэлд БНКаЗУ-ын Засгийн газраас нийт хүн амд эзлэх казах үндэстний тоог нэмэгдүүлэх, угсаатны бүтцийг өөрчлөхийн тулд 1991 оноос хойш 30 орчим жилийн хугацаанд хэрэгжүүлж буй

Казахстан улсын угсаатны шилжилт хөдөлгөөний бодлого, түүний үр дүн

шилжилт хөдөлгөөний (цагаачлал) бодлогын хэрэгжилт, түүний үр дүнд задлан шинжилгээ хийхийг зорилоо.

Түлхүүр үг: *Бүгд Найрамдах Казахстан Улс, хүн ам зүйн бодлого, угсаатны бүтцийн өөрчлөлт, диаспора, казах үндэстний шилжилт хөдөлгөөн*

Оршил

1991 онд БНКаЗУ нь ЗХУ-ын бүрэлдэхүүнээс гарч, тусгаар тогтнолоо зарласан. Энэ үеэс БНКаЗУ-д улс төр, нийгэм, эдийн засгийн шинэчлэл, ардчиллын үндсийг бүрдүүлэхэд чиглэгдсэн асар их ажлууд хийгдэж эхэлсэн. Үүний нэг болох хүн амын угсаатны бүтцийг өөрчлөх бодлого нь төр засгийн удирдлагуудаас асар их хүчин чармайлт шаардсан ажил байсан юм. Тухайн үед нийт хүн амд казахууд ердөө 39.7%-ийг эзлэж¹, хүн амын дийлэнх олонхийг (60.3) казах биш угсаатнууд бүрдүүлж байжээ. Мөн ЗХУ-ын бүрэлдэхүүнд байх үед казах угсаатны уламжлалт ёс заншил, хэл, соёл ихээр алдагдсан тул “*казах угсаатны уламжлалт зан заншил, хэл соёлыг хадгалан хамгаалах, дахин сэргээх*” нь улс орны шийдвэрлэх чухал асуудлын нэг байлаа.

Иймд тус улсын Засгийн газраас “*хүн ам зүйн цогц бодлого*” баримталсны зорилго нь нийт хүн амд казах угсаатны хэмжээг нэмэгдүүлэхийн тулд хилийн чанадад амьдардаг казах хэлтэй элэг нэгтнүүдийг “*түүхэн эх нутагт*” (БНКаЗУ-д) нь буцаан суурьшуулах (repatriation) явдал байлаа. Казах угсаатнуудыг түүхэн эх нутагт нь эргүүлэн татах бодлого нь хуучин ЗХУ-ын үед шилжин явсан орос хэлээр ярьдаг казах угсаатнууд руу биш, харин зэргэлдээх болон гадаад орнуудад амьдардаг казах хэлээр сайн ярьдаг, уламжлалт соёл,

¹ Dave, Bhavna, and Sinnott, Peter, 2002. “Demographic and Language Politics in the 1999 Kazakhstan Census,” Watson Institute, Brown University, the National Council for Eurasian and East European Research. pp. 2.

ёс заншлаа хадгалан авч үлдсэн казах угсаатнуудыг БНКаЗУ-д буцаан суурьшуулахад чиглэгджээ. 1991 оноос хэрэгжүүлсэн тус бодлогын хүрээнд БНКаЗУ нь өнөөдөр дэлхийд тархан суурьшсан казахуудаас ойролцоогоор 1.8 сая хүнийг² улс орондоо буцаан суурьшуулаад байна.

Монгол Улс, БНКаЗУ хооронд 1992 оны 1 дүгээр сард дипломат харилцаа тогтоосноос хойш хоёр орны харилцаа хамтын ажиллагаа улс төр, эдийн засаг, соёлын болон бусад салбарт амжилттай хөгжих болсон юм. Тухайн үед Монгол Улс БНКаЗУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоосон анхны улсуудын нэг байсан. Түүхэн шинэ замыг сонгож, тулгар төрөө төвхнүүлж эхэлсэн БНКаЗУ-ыг дэмжих хэд хэдэн онцгой нөхцөл Монгол Улсад байсан юм.

Нэгдүгээрт, хоёр улсын аль алинд нь казах угсаатан оршин амьдардаг. Хоёрдугаарт, Зөвлөлт тогтолцооны үед Монгол Улс Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Казахстан Улстай (ЗСБНКУ) эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн болон хүмүүнлэгийн өргөн харилцаатай байсан. Гуравдугаарт, үндэснийхээ соёл уламжлалыг сэргээн хөгжүүлэхэд Монгол Улс, БНКаЗУ-д туслах боломжтой.

Тиймээс БНКаЗУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн хүн амын шилжилт хөдөлгөөний бодлогын хүрээнд хэл соёл, ёс заншлаа сайтар хамгаалан үлдсэн Монгол Улсын казах иргэд шилжилт хөдөлгөөнд татагдан оролцсон юм. 1991 оны 9 дүгээр сард Монгол Улс, БНКаЗУ-ын Хөдөлмөрийн яамдын хооронд таван жилийн хугацаатайгаар Монгол Улсын казах иргэдийг БНКаЗУ-д ажиллуулах талаар хамтарсан хөдөлмөрийн гэрээ хэлэлцээрийг байгуулжээ. Тус хөдөлмөрийн гэрээний дагуу Монгол Улсаас казах иргэд БНКаЗУ-ын нэгдэл, сангийн аж ахуйд ажиллахаар явах болсон байна. Ийнхүү Монгол Улсын казах иргэдийн БНКаЗУ руу шилжин явах үйл явц өрнөж, казах иргэдийн дундах анхны шилжилт хөдөлгөөний томоохон урсгал ийнхүү эхэлсэн байна. 1991-1993 оны хооронд хөдөлмөрийн гэрээгээр 12257 өрхийн 60 орчим мянган³ (үүнээс

² Agentstvo Respubliki Kazakhstan po Statistiki, 2018. “Kazakstan Fsifrah 2008-2018, Statistichiskih Sbornik,” Astana, pp. 9-12,

³ Казахстан- Монголия 20 жыл “Монгол: Найрсаг харилцаа хамтын ажиллагааны 20

20 гаруй мянга нь хөдөлмөрийн чадвартай) иргэн Монгол Улсаас БНКаЗУ-д шилжин суурьшсан гэх албан мэдээ байдаг. Мөн албан бус мэдээгээр, 1991-2018 оны хооронд Монгол Улсын нийт 100 орчим мянган казах иргэд БНКаЗУ-д шилжин суурьшсан байна.

Энэхүү өгүүлэлд 1991 оноос хойш 30 орчим жилийн хугацаанд БНКаЗУ-ын засгийн газраас хэрэгжүүлсэн угсаатны шилжилт хөдөлгөөний бодлогыг (*ethnic return migration policy*) хэрэгжүүлэх болсон шалтгаан хийгээд түүний үр дүнд хилийн чанад дахь казах угсаатнуудыг хэрхэн түүхэн эх нутагт нь суурьшуулж чадсан талаар тусгайлан авч үзсэн болно. Энэ бүгдийг хураангуйлах үүднээс БНКаЗУ-ыг зорьсон Монгол Улсын казах угсаатны нүүдэл шилжилтээр жишээ болгон өгүүлэхийг зорив.

Шилжилт хөдөлгөөний бодлого хэрэгжих болсон шалтгаан, түүхэн нөхцөл байдал

ЗХУ задарснаар түүний бүрэлдэхүүнд байсан ЗСБНКУ 1991 оны 12 дугаар сарын 16-ны өдөр БНКаЗУ болон албан ёсоор тусгаар тогтнолоо зарлажээ. Тусгаар тогтнолоо зарласан даруйдаа хүн амын угсаатны бүтцийг өөрчлөхийн тулд шилжилт хөдөлгөөний томоохон бодлого хэрэгжүүлж эхэлсэн нь хилийн чанадад, ялангуяа БНХАУ, Монгол, Турк болон бусад Төв Азийн орнуудад амьдардаг казах угсаатнуудыг түүхэн эх нутаг болох шинээр тусгаар тогтносон БНКаЗУ-д эргүүлэн татаж, буцаан суурьшуулах зорилготой байлаа. Энэ нь хүн амын угсаатны бүтцийн харьцааг тэнцвэржүүлэх, нийт хүн амд казахуудын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай уялдан зүй ёсоор гарч ирсэн түүхэн шаардлага байсан юм. Учир нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд байх хугацаанд казах хэл соёл, уламжлалт ёс заншил ихээр алдагдаж, ард түмэн нь ерөнхийдөө “оросжсон” тул улс орон оршин тогтноход хүн амд казах үндэстний үзлийг төлөвшүүлэх, “үндэсний өвийг сэргээх, хадгалан хамгаалах”-ыг эрмэлзэж байв.

жил” Улаанбаатар, 2013.

Тиймээс дэлхийгээр тархан амьдарч буй казах угсаатнуудыг түүхэн эх оронд нь эргүүлэн татсанаар казах үндэсний хэл, өв соёлыг сэргээх, хадгалах, хамгаалахад шилжин ирэгчид ихээхэн үүргийг гүйцэтгэнэ гэж үзжээ.

Түүхэн шалтгаанаар эх орноосоо дүрвэн хилийн чанадад амьдрах болсон элэг нэгтнүүдийг (диаспора) буцааж татах бодлогыг Израйль, Герман улсууд 1945-1985 онд хэрэгжүүлжээ. Дайны үед гадаад улсуудруу дүрвэн гарсан герман угсаатнуудыг татах бодлого явуулж, 1945-1985 онуудад нийтдээ 10 сая герман угсаатныг ХБНГУ-д татаж, дахин суурьшуулж чадсан байна. Мөн Израйль улс 1948 оны тусгаар тогтнолын тунхаглалд “еврей цагаачдыг шилжүүлэн суурьшуулахад нээлтэй байх болно” гэж зарлаж, 1949-1951 онуудад 700 мянган еврейг⁴ эх орондоо буцаан суурьшуулжээ.

БНКазУ нь Израйль Германы диаспоруудыг түүхэн эх нутаг нь эргүүлэн татах бодлогыг нутагшуулсан байна. БНКазУ-ын бодлого боловсруулагчид ямагт нэг үндэстний ахан дүүс гэсэн сэтгэлээр хандан, шинээр тусгаар тогтносон улс орныхоо “үндэсний нийтлэг шинжийг хадгалах, үндэсний үзэл, ашиг сонирхол”-д суурилсан шилжилт хөдөлгөөний бодлогыг боловсруулжээ. Өөрөөр хэлбэл, гадаад орнуудаас ирсэн казах диаспорачууд нь хүн амзүйн бодлогын хувьд үндэсний үзэл, хэл соёлыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзжээ. 1992 оны 9 дүгээр сард БНКазУ-ны засгийн газар казах угсаатнуудынхаа тоог нэмэгдүүлэхийн тулд дэлхий даяар тархсан казахуудын төлөөллийг урьж Алмата хотноо “Дэлхийн Казах Үндэстний Хуралдай”-г (World Kazakh Association) зохион байгуулж, казах угсаатнуудыг шилжүүлэн суурьшуулах талаар ил тод хэлэлцсэн байна. Ерөнхийлөгч Н.А.Назарбаевын санаачилгаар казах угсаатнуудын БНКазУ руу нүүж ирэх урсгалыг эрчимжүүлэх зорилготой “байнгын хороо”-г ч байгуулжээ. Тус хуралдайн тогтоолд дэлхийн бүх казахуудыг БНКазУ-ын газар нутагт, нэг

⁴ Yehuda Dominitz, “Israel’s Immigration Policy and the Dropout Phenomenon”, in *Russia Jews on Three Continents: Migration and Resettlement*, eds Noah Lewin-Epstein, Yaacov Ro’l and Paul Ritterband (London:Frank Cass, 1997) p.114

Казахстан улсын угсаатны шилжилт хөдөлгөөний бодлого, түүний үр дүн

дээвэр дор нэгдэхийг уриалжээ. Энэ уриалгад нүүж ирэх казахуудад эдийн засгийн боломжоор хангах, дэмжлэг үзүүлэхээр амласан нь Монгол, Хятад, Иран, Киргиз ба бусад улсуудын казахуудыг олноор БНКаЗУ-д шилжин нүүхэд нөлөөлжээ.

Хилийн чанадад амьдарч буй казах угсаатнууд (диаспора)

Улс	Талгат Мамашиев	Гулнара Мендикулова
	Хүн ам /мян/	Хүн ам /мян/
БНХАУ	1296	1825
Узбекистан	1200	1500
ОХУ	660	800
Монгол	157	100
ТУХН	230	215
Афганстан	45	30
Турк	30	10
Иран	15	10
АНУ	10	10
Герман	7	2
Канад	5	7
Франц	4	2
Швед	1	0.5
Нийт	3660	4511.5

*Эх сурвалж: Макаш Татимов: Казах диаспоранын этнодемографиясы, Жана егемен казахстан журналы, Гулнара Мендикулова: Теоретико- методологические и научно-практические основные исследования казахской диаспоры и ирреденты”
Казах Диаспорасы: бүгинги мен ертенги –Казахстан Диаспора: настоящее и будущее (Астана Елорда 2005)*

Дээрх хүснэгтэд хилийн чанадад амьдарч буй казах диаспорагийн хэмжээг, хоёр өөр эрдэмтний тооцоолсноор харуулав. Тэдгээр эрдэмтдийн тооцоолсноор дэлхийн улс орнуудад 3.6-4.5 сая казах угсаатнууд тархан суурьшсан байна. БНКаЗУ-ын засгийн газраас 2010 оныг хүртэл нийт 3 сая шилжин ирэгчдийг хүлээн авахаар төлөвлөжээ.

Шилжих хөдөлгөөний явц ба түүний үечлэл, хэрэгжилт

БНКаЗУ-ын шилжин ирэгчдийн тухай анхны хууль 1992 онд батлагдсан. Тус хуульд зааснаар “шилжин ирж буй элэг нэгтнүүдэд Засгийн газраас санхүүгийн тусламж дэмжлэг үзүүлнэ. Үүнд: амьдрах орон байр, ажлын байр, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мөн суурьшихад зарцуулах нэг удаагийн мөнгөн тусламж олгох” гэжээ. Шилжилт хөдөлгөөний бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн анхны он жилүүдэд дэлхийн өнцөг булан бүрээс БНКаЗУ-ыг зорин ирэх олон тооны шилжин ирэгчид нь орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах хороонд бүртгүүлэн, тэтгэлэгт хамрагддаг байжээ. Анхны шилжин ирэгчид “*таван жилийн хөдөлмөрийн гэрээ*”-гээр суурьшсан⁵ байна. Иргэншил олгох талаар нарийн заалт байхгүй байжээ. Тэдгээрийг бүртгэх, хянах түүгээр дамжуулан тэтгэлэг олгох үйлчилгээг хүртээж байсан байна. Тухайн үед шилжин ирэгчдийн иргэншил нь зөвхөн “*оралман*” статустай байсан (*оралман-элэг нэгтэнүүд*).

1997 онд шилжин ирэгчдийг хүлээн авах шинэчилсэн хууль батлагджээ. Энэхүү хуулиар оралманчуудын “иргэншил харьяат”-ын асуудлыг шийдвэрлэх, БНКаЗУ-ын иргэншил олгох⁶ талаар тусгажээ. Таван жилийн гэрээний хугацаа дууссаны дараагаар хүн амын

⁵ Diener, Alexander, 2003. “One Homeland or Two: Territorialization of Identity and the Migration Decision of the Mongolian-Kazakh Diaspora,” Ph.D Dissertation, Madison: The University of Wisconsin, pp. 14,

⁶ Kazakhstan, 1997. Law on Migration, Kazakhstan 1997: 4-5, Article No. 9

тогтвортой суурьшлын асуудал хөндөгдсөн тул шилжин ирэгчдийг тус улсын иргэншилтэй болгох шаардлага гарч ирсэн. Өмнөх хуулиас ялгаатай нь нүүж ирсэн иргэн болгонд тэтгэлэг олгохгүй, зөвхөн БНКазУ-ын иргэншил авсан тохиолдолд хангамж мөнгөн тусламжийг олгохоор тусгажээ. Улс орны эдийн засгийн өсөлттэй уялдуулан тэтгэлэг хангамж олгох, хүмүүсийг нүүдэллэн очиход нь муж, хот тосгон, аж ахуй, байгууллагад хувиарлалт хийхдээ аль болох шилжин ирэгчдийн санал хүсэлтийг харгалзах, ах дүү, найз нөхдөөр нь хамт хуваарилах, казах иргэдийн иргэншлийн асуудлыг тэдний саналын дагуу шуурхай шийддэг болох, тэдний ажил, албан тушаал, нийгмийн халамж, амьдралын олон асуудлыг шийдвэрлэж өгөх талаар тодорхой тусгаж өгсөн байна. 1997 онд гарсан хуульд 2002 онд нэмэлт өөрчлөлт хийж, шилжин ирэгчдийг тус улсын харъяат иргэн олгох нөхцөлийг илүү хялбар болгож тусгажээ.

2000 онд шилжин ирэгчдийн бодлогын хөтөлбөр боловсруулсан бөгөөд 2001-2009 оны хооронд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Тус хөтөлбөрт гадаад орнуудаас шилжин нүүж ирсэн казах иргэдийг шинээр хөгжиж буй сум суурин газруудад суурьшуулахаар тусгажээ. Тусламж тэтгэлгийн хэмжээг алслагдсан сум сууринд нүүж очигсдод түлхүү олгох, илүү түргэн шуурхай олгож, тэдний нийгмийн асуудалд төрөөс түлхүү анхаарна гэж заажээ. Тухайлбал: орон сууц, ажлын байраар хангах, бага хүүтэй олон жилийн зээл олгох зэрэг алслагдсан бүс нутагт хүн амыг жигд суурьшуулахад чиглэгдсэн хөтөлбөр⁷ байжээ. Засгийн газраас олгох нэг удаагийн тусламж тэтгэлэгт шилжин ирсэн өрхийн гишүүн тус бүр нэг мянган ам.доллар, өрхийн хэрэгцээнд хашаа байшин, мал, мэргэжлийг нь харгалзан ажлын байр, нийгмийн үйлчилгээ гэх мэт дэмжлэгүүд багтжээ. Тухайн үед БНКазУ-аас олон тооны орос, герман бусад слав угсаатнууд мөн өөрсдийн нутаг руу шилжин явжээ. Шилжин явагчид нь орон сууц, хашаа байшин, мал эд хөрөнгөө үлдээн нутаг буцжээ. БНКазУ-ын

⁷ Enbek, 2008/12. Postanovlenie Pravitelstva Respubliki Kazahstan ot 2 dekabrya 2008 goda, №1126, "Programma Nurly Kosh na 2009-2011 gody," Ministerstvo Truda i Sosialinoi Zashity Naseleniya, Enbek Gov. KZ, <http://www.enbek.gov.kz/migration/migr_rusdetail.php?recordID=52&mintrud=1>

засгийн газраас шинээр шилжин ирсэн казах угсаатнуудад БНКаЗУ-аас шилжин явагчдын орон байр, мал эд хөрөнгийг тэтгэлэг болгон олгожээ.

2000 онд “дунд хугацааны 2000-2005 онд, урт хугацааны 2005-2009 онд” хэрэгжүүлэх шилжилт хөдөлгөөний хөтөлбөр батлагдсан. Дунд хугацаанд хэрэгжүүлэх шилжилт хөдөлгөөний хөтөлбөрт шилжин ирэгчдэд тулгамдаж буй бэрхшээлийг арилгах, тэдний иргэншилтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгджээ. Урт хугацаанд хэрэгжүүлэх хөтөлбөрт шилжин ирэгчдийг “*алслагдсан жижиэг тосгон сум, суурин газарт суурьшихад тэтгэлгийн хэмжээг нэмэгдэлтэй олгохоор*” тусгажээ. Энэ үед засгийн газраас олгож буй тэтгэлэг нь шинээр шилжин ирэгчдэд хангалтгүй байсан тул тэдгээр иргэд шинэ газар нутагт дасан зохицож амьдрахад зарим нэг бэрхшээлтэй тулгарч⁸ байжээ. Учир нь Засгийн газраас шилжин ирэгчдэд олгох тэтгэмж, туслалцааны хувь хэмжээ нь улс орны эдийн засгийн өсөлт бууралттай холбоотойгоор харилцан адилгүй байжээ.

Шилжин ирэгчдийг хүлээн авах дараагийн хөтөлбөр нь 2009 онд “Нурлы-Көш” буюу “Гэрэлт-Нүүдэл” нэртэйгээр батлагдаж, 2009-2011 оны хооронд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Нурлы-Көш хөтөлбөрт хуучин тус улсын иргэн байсан одоогоор гадаадад ажиллаж буй мэргэжлийн чадварлаг ажиллах хүчийг БНКаЗУ-д эргэн ирж ажиллаж амьдрах, шинээр баригдаж буй алслагдсан сум, суурингуудад шилжин ирэгчдэд тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлэх гэсэн заалтуудыг нэмж тусгажээ. Өөрөөр хэлбэл: ОХУ-тай хиллэдэг нутгийн хойд бүс нутагт тэтгэлэг квотыг түлхүү олгох, баруун болон өмнөд бүс нутгуудаас казах өрхүүдийг хойд мужуудад шилжүүлэн суурьшуулах нэмэлт заалтууд тусгагджээ. Мөн 2011 онд болсон Дэлхийн Казахуудын Хуралдайгаар БНКаЗУ-д шилжин ирэгчид болон гадаадад амьдарч буй казах угсаатнуудыг дэмжих үйл ажиллагааг идэвхижүүлэх, шилжин ирэгчдэд тулгарч буй саад

⁸ Diener, Alexander, 2003. “One Homeland or Two: Territorialization of Identity and the Migration Decision of the Mongolian-Kazakh Diaspora,” Ph.D Dissertation, Madison: The University of Wisconsin, pp. 140,

бэрхшээлийг арилгах, тэдэнд төрөөс үзүүлэх дэмжлэг туслалцааг нэмэгдүүлэхээр шийдвэрлэжээ.

2011 оны 12 дугаар сард газрын тос олборлодог Жана-Өзен хотод газрын маргаанаас үүдэлтэй үйлдвэрийн ажилчид хамгаалалтынхантай зөрчилдөж, 15 хүний амь үрэгдсэний дараа засгийн газраас гадаад орнуудаас казах угсаатнуудыг татах хөтөлбөрөө түр зогсоосон. Энэхүү зөрчил маргаан нь гадаадаас ирсэн шилжин ирэгчид (оралман)-ээс үүдэлтэй гэж үзэж, гадаад орнуудаас казах угсаатнуудыг татах хөтөлбөрийг БНКаЗУ-ын уугуул иргэд зогсоохыг засгийн газраас шаардсантай холбоотой байжээ. Гэвч 2014 оны 3 дугаар сард ОХУ нь Крымын хойгийг Украйнаас салгасны дараа “хойд бүс нутгууддаа казах угсаатныхаа тоог нэмэгдүүлэхийн тулд шилжилт хөдөлгөөний хөтөлбөрөө дахин сэргээсэн” байна. Костанай, Павладор болон нутгийн хойд мужуудад казах биш угсаатнууд нь казахуудын тооноос олон тул дээрх мужуудад шилжин ирсэн казах угсаатнуудад засгийн газраас орон байр, ажил сургууль, нүүх зардал зэрэгт нь дэмжлэгийг түлхүү олгохоор заажээ.

Шилжилт хөдөлгөөнийг зохицуулах шинэчлэгдсэн хөтөлбөр 2017 оны 9 дүгээр сарын 28-нд (Концепции миграционной политики Республики Казахстан на 2017-2021 годы) батлагдаж, 2017-2021 онуудад хэрэгжихээр⁹ болсон байна. Засгийн газраас шилжин ирэгчдэд оршин суух газрыг тусгайлан зааж, дэмжлэг туслалцаа, тэтгэлгийг хөдөөгийн шинээр баригдаж буй бүс нутагт түлхүү олгох, шинээр шилжин ирэгчдийн хүүхдүүдийг их дээд сургуульд тэтгэлэгтэй, үнэгүй суралцуулах заалт орсон. Мөн тэтгэвэрт гарах шалгуур үзүүлэлтэнд өөрчлөлт орж, тэтгэвэрт гарах хүмүүс БНКаЗУ-д заавал “20-оос дээш жил ажиллаж, хөдөлмөрлөсөн байх ёстой” гэсэн нэмэлт заалтууд орсон байна.

Өнгөрсөн гуч орчим жилийн хугацаанд хүн амын шилжилт хөдөлгөөний бодлого хэрхэн өөрчлөгдсөнийг хүн амын шилжилт хөдөлгөөний үйл явцтай холбон тайлбарлаж, тоймлон үзвэл:

⁹ <https://www.enbek.gov.kz/ru/node/345460>

- 1991-1999 онуудад “өөрчлөлт шинэчлэлийн үеийн шилжилт хөдөлгөөний бодлого”-ыг хэрэгжүүлсэн үе бөгөөд шинээр тусгаар тогтнож, улс төр, нийгэм, эдийн засгийн шинэ системд шилжиж, ихээхэн сорилт бэрхшээлүүдтэй тулгарсан үе байлаа. Энэ үед гадаад орнуудаас шилжин ирэгчид нь БНКаЗУ-ын талаар төсөөлөлгүй, аль хот тосгонд очин, хэрхэн амьдрах талаар тодорхой ойлголтгүй байжээ. Нийт шилжин ирэгчдийн 2/3 хувийг эхний арван жилд хүлээн авсан. Энэ үед хүн амын “*замбараагүй шилжилт хөдөлгөөн*” давамгайлж байжээ. Таван жилийн хөдөлмөрийн гэрээ нь тодорхой бус гэрээ байжээ. Шилжин ирэгчдэд тус улсын иргэншил олгох заалтгүй тул шилжин ирэгчид нь орхин гарсан улс руугаа дахин нүүх, хүн амын тогтвортой суурьшлын асуудал хөндөгдөж эхэлсэн байна. Энэ үед БНКаЗУ-ын төр засгаас казах угсаатны хэл, соёл уламжлалт үнэт зүйлийг хадгалан хамгаалах, цагаачдыг хүлээн авах, тэднийг дэмжих талаар ихэд дэмжиж ажилласан он жилүүд байжээ.
- *2000-2009 онд шилжин ирэгчдэд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэсэн зохион байгуулалттай шилжилт хөдөлгөөний бодлого хэрэгжүүлсэн үе.* Энэ үед шилжилт хөдөлгөөний бодлого хөтөлбөрт хэд хэдэн шинэчилсэн заалтыг нэмж сайжруулсан байна. Шилжин ирэгчдийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх тэдэнд орос хэлний боловсрол олгох, иргэншил авахад орон нутгийн шилжилт хөдөлгөөний зохицуулах хороо түргэн шуурхай ажиллах зэрэг тодорхой заалтуудыг оруулсан байна. Энэ үед эрчим хүч, газрын тосны үнэ дэлхийн зах зээлд унаж, улс орны эдийн засгийн өсөлт саарсан үе байлаа. Улмаар хотжилт ихсэж, хот хөдөөгийн ялгаа улам гүнзгийрсэн тул засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого хөдөө аж ахуй, мал аж ахуй, ялангуяа хөдөөгийн алслагдсан тосгон суурин газрыг хөгжүүлэхэд чиглэгджээ. Тухайлбал: 2000 онд шилжин ирэгсдийн тоо 1991 оны цагаачдын тооноос 5 дахин, 1995

Казахстан улсын угсаатны шилжилт хөдөлгөөний бодлого, түүний үр дүн

оныхоос гурав дахин бага байжээ.

- 2010-2019 онд зорилтот бүлэгт түлхүү чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний бодлого хэрэгжүүлсэн бөгөөд шилжиж ирэгчдийн тоо эрс багассан үе. Энэ үед шилжилт хөдөлгөөний бодлого хөдөлмөрийн чадвартай залуу боловсон хүчин мэргэжилтнүүд, их дээд сургуулийн оюутнуудад дэмжлэг туслалцааг түлхүү олгохоор болжээ.

Казахстаны угсаатны бүтцэд гарсан өөрчлөлт, үр дүн

БНКаЗУ-д хүн амын шилжилт хөдөлгөөний урсгал 1991 оноос хойш эрчимтэй явагдаж, 2018 оны байдлаар тус улс нь олон улсын шилжих хөдөлгөөний 0.4%- ийг эзлэж¹⁰ байна. 2005 оны байдлаар шилжин ирэгчдийг ихээр хүлээн авагч орон буюу дэлхийд 9 дүгээр байранд орж байсан бол 2018 оны байдлаар 12 дугаар байранд орж байна¹¹. БНКаЗУ нь 2.7 сая км² нутаг дэвсгэртэй бөгөөд 2018 оны байдлаар 18 сая 277 мянган хүн амтай байв. Энэ нь нэг километр квадрат нутагт дунджаар 6.7 хүн ноогдож, хүн амын нягтаршлын хувьд сийрэгт тооцогдох улс орон гэдгийг харуулж байна.

Энэхүү бодлогын хүрээнд 1991-2015 онд дэлхийн 40 гаруй орноос казах угсаатныг хүлээн авсан байна. Ойролцоогоор 1 сая 800 мянган хүн БНКаЗУ-ын харьяат иргэн болж, тэдгээр шилжин ирэгчид нь тус улсын нийт хүн амын 10.2%-ийг эзлэж байна. Шилжин ирэгчдийн 9.2%- ийг Монгол Улсаас очсон казах иргэд, Узбекистан 61%, Туркменистан 4.6%, БНХАУ 14.2%, ОХУ 3.6%, Тажикистан 2%, Иран 1%, Турк 1%, Киргизстан 1%, бусад ТУХН-ийн орнуудаас 1%-ийг тус тус¹² эзлэж байна. 2010 оноос хойш БНКаЗУ-ын засгийн

¹⁰ International Organization for Migration “World Migration Report 2018”

¹¹ International Organization for Migration “World Migration Report 2018”

¹² Agentstvo Respubliki Kazakhstan po Statistiki, 2018. “Kazakstan Fsifrah 2008-2018, Statistichiskih Sbornik,” Astana, pp. 9-12

ОЛОН УЛС СУДЛАЛ

газраас шилжин ирэгчдийн хөдөлмөр эрхлэлт, тэдэнд орос хэлний боловсрол олгох, эрүүл мэндийн даатгал, орон сууцжуулах гэх мэт тэтгэлэгт нийт 130 сая ам.доллар зарцуулсан албан бус мэдээлэл байна.

1989 оны байдлаар нийт хүн амд эзлэх казах угсаатнууд 39.7% байсан бол 2018 онд 70.6% болж өсчээ.

БНКазУ-ын угсаатны бүтэц, (1959-2018 он, хувь)

Угсаатан (%)	1959	1970	1979	1989	1999	2009	2018
Казах	30.0	32.6	36.0	39.7	53.4	63.1	70.6
Орос	42.7	42.4	40.8	37.4	29.9	23.7	22.4
Украйн	8.2	7.2	6.1	5.4	3.7	2.1	1.9
Герман	7.1	6.6	6.1	5.8	2.4	1.1	0.9
Татар	1.5	2.2	2.1	2.0	1.7	1.3	1
Узбек	1.1	1.7	1.8	2.0	2.5	2.8	2.3
Беларусь	1.2	1.5	1.2	1.1	0.8	1.0	0.9

Эх сурвалж: 1959-1999 оны мэдээг Бавна Даве, Петер Синнот “БНКазУ-ын Хэл болон Хүн амын бодлого 1999 он,” 2002:22., 2009-2018 мэдээг “Хүн амын Статистикийн эмхэтгэл 2008-2018,” БНКазУ-ын Үндэсний Статистикийн Хороо, Астана 2018.

Тус улсын нийт хүн амд эзлэх казах угсаатны эзлэх хувь хэмжээ нэмэгдэхэд шилжилт хөдөлгөөний бодлогын хэрэгжилтээс гадна хүн амын ердийн өсөлт их байсан нь нөлөөлсөн юм. 1991 оноос хойш БНКазУ-аас гадагшаа шилжин явсан казах бус угсаатнуудын тоо их байсан бөгөөд нийт 3.4 сая орос, герман, слав угсаатнууд¹³ шилжиж

¹³ UNDP, 2006. “Oralman of Status in Kazakhstan,” Overview, UNDP Kazakhstan, Almaty, pp. 4-15.

явсан зэрэг нь нийт хүн амд казахуудын эзлэх хэмжээг нэмэгдүүлж, угсаатны бүтцийг эерэгээр өөрчлөхөд нөлөөлсөн хүчин зүйлүүдийн нэг юм.

Монгол Улсаас шилжилт хөдөлгөөнд оролцогчдын урсгал, дүр зураг

Монгол Улс 1990-ээд оны эхэн үедулс төр, нийгэм эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлт хийн, зах зээлийн эдийн засагт шилжих явцад хүн амын дунд ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, ажлын байрны хомсдол үүссэн билээ. Энэхүү нийгэм эдийн засгийн шинэчлэлийг даган хөдөөнөөс хот суурин газар руу, хот суурин газраас гадаад улс орнууд руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн явагдаж эхэлсэн. Мөн 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуульд Монгол Улсын иргэн өөрийн оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй гэж заасан. Энэ тулгуур зарчим болон хоёр орны засгийн газар хооронд байгуулсан “Таван жилийн хөдөлмөрийн гэрээ”-нд үндэслэн 1991 оноос Монгол Улсын казах иргэд шилжилт хөдөлгөөнд оролцож эхэлсэн байна.

Монгол Улсын хувьд тухайн үед нийгэмд үүссэн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийг ажлын байраар хангах сонирхолтой байсан. Иймд Монгол Улсын Засгийн газраас ажиллах хүчний нөөц ихтэй баруун бүсийн Баян-Өлгий, Ховд аймгуудын хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс казах иргэдийг тус шилжилт хөдөлгөөнд оролцох эрхийг олгожээ.

Тухайн үед эдийн засгийн суурь хүчин зүйл болох “*ажилгүйдэл ядуурал*” нь Монгол Улсаас казах иргэд БНКаЗУ руу олноор шилжин явахад хүргэсэн гол түлхэх хүчин зүйл (push factor) байжээ. Харин БНКаЗУ-ын Засгийн газраас гаргасан гадаад орнуудаас казах угсаатнуудыг БНКаЗУ-д ажиллаж, амьдрахад санхүү, эдийн засгийн (ажлын байраар хангах, мөнгөн тусламж-квот олгох, бусад дэмжлэг туслалцаа үзүүлэх) болон түүхэн уламжлалт хэл, соёлоо хадгалан

хамгаалахад дэмжлэг туслалцаа үзүүлнэ гэсэн бодлого нь татах хүч (pull factor) болжээ¹⁴. Зарим судлаачдын бүтээлд дурдсанаар 1991–2000 оны хооронд Монгол Улсаас хамгийн олон ойролцоогоор 100 гаруй мянган казах иргэд БНКазУ-д шилжин явж, үүнээс 10 гаруй мянган иргэд хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссаны дараагаар Монгол Улсад¹⁵ буцаж ирсэн байна. Ахмад настай, эрүүл мэндийн байдал, тухайн нутгийн уур амьсгалд нь дасан зохицож чадаагүй иргэд Монгол Улсад буцаж¹⁶ иржээ. Монгол Улсын казах иргэдийн шилжилт хөдөлгөөн хамгийн идэвхитэй явагдсан эхний жилүүдэд (1991-1999) Баян-Өлгий, Ховд, Улаанбаатар хотын Налайх дүүргийн иргэд голлон энэхүү шилжилт хөдөлгөөнд оролцсон байна¹⁷.

2000-2010 онд казах иргэдийн шилжилт хөдөлгөөний эрч суларч, гэр бүл, хамаатан садан, олноор шилжин явах үйл явц багасчээ. Энэ он жилүүдэд голлон хөдөөгийн малчин өрхүүд байгаль цаг уурын гамшигт өртөж, жил дараалан үргэлжилсэн байгалийн ган зудын хор уршгаар малаа хорогдуулж, амьжиргаа залгуулах аргагүй болсон иргэд голлон шилжин явсан байна. Мөн энэ үед орлого багатай бэлчээрийн мал аж ахуй эрхлэлтээс ангижирч, суурин аж төрөх хэлбэрт шилжих хандлагатай байжээ. Зарим судалгаанаас харахад Монгол Улсын нийслэл Улаанбаатар, Төвийн бүсийн Дархан, Эрдэнэт, Хэнтий аймгуудаас казах иргэд шилжилт хөдөлгөөнд голлон оролцсон байна. Шилжин явагчид нь голлон БНКазУ-ын гадаадад амьдарч буй казах иргэдийн хэл соёлыг дэмжих хөтөлбөрт хамрагдах хүсэл сонирхолтой байжээ.

¹⁴ Werner, Cynthia and Barcus Holly, 2009. “Mobility and Immobility in a Transnational Context: Changing Views of Migration among the Kazakh Diaspora in Mongolia”, Migration Letter, Vol.6, No.1, pp. 50-51.

¹⁵ Diener, Alexander, 2003. “One Homeland or Two: Territorialization of Identity and the Migration Decision of the Mongolian-Kazakh Diaspora,” Ph.D Dissertation, Madison: The University of Wisconsin, pp. 316

¹⁶ Barcus, Shugatai 2018, “Immobile Populations as Anchors of Rural Ethnic Identity: Contemporary Kazakh Narratives of Place and Migration in Mongolia” Population, Journal, Space & Place Special Issue

¹⁷ Barcus, Shugatai 2018, “Immobile Populations as Anchors of Rural Ethnic Identity: Contemporary Kazakh Narratives of Place and Migration in Mongolia” Population, Journal, Space & Place Special Issue

2010-2019 онд Монгол Улсаас казах иргэд гэр бүлээр шилжин явах явдал багасаж, түр хугацаагаар хөдөлмөр эрхлэх, ганц бие хөдөлмөрийн насныхан болон их дээд сургуульд сурч боловсрох сонирхолтой оюутан залуус голлон шилжилт хөдөлгөөнд оролцох үйл явц ажиглагдаж байна. Түр хугацаагаар шилжигчид нь Монгол Улсад үлдсэн ар гэрийхэндээ мөнгө илгээж байгаа нь өрх гэрийн орлогыг хангах нэг гол үүсвэр болж байна. БНКаЗУ их дээд сургуульд суралцагчдад үнэгүй боловсрол олгодог тул Монгол Улсаас казах оюутнууд их дээд сургуульд суралцахын тулд БНКаЗУ-ыг зорих, оюутнуудын тоо ихсэх хандлагатай байна.

Дүгнэлт

БНКаЗУ ЗХУ-ын бүрэлдэхүүнээс гарч тусгаар тогтнох үед нийт хүн амын дийлэнх олонх хувийг казах биш угсаатнууд бүрдүүлж, казахын хэл соёл, үндэсний уламжлалт ёс заншил нь ерөнхийдөө алдагдсан байжээ. БНКаЗУ-д шинээр тусгаар тогтносон он жилүүдэд казах хэлээр сайн ярьдаг ёс заншлаа хадгалан үлдсэн казах хүмүүсийн эрэлт хэрэгцээ өндөр байжээ. Иймд БНКаЗУ-ын Засгийн газраас казах угсаатнуудад чиглэсэн шилжилт хөдөлгөөний тусгай бодлогыг идэвхитэй хэрэгжүүлж, дэлхийн өнцөг булан бүрээс казах угсаатнуудыг түүхэн эх нутагт нь буцаан суурьшуулах үйл ажиллагааг эрчимтэй явуулжээ.

Энэхүү шилжилт хөдөлгөөний бодлого нь хүн амын угсаатны бүтцийг тэнцвэржүүлэх, үндэстний нийтлэг шинжийг хадгалах хамгаалах, уламжлалт хэл соёлоо сэргээх замаар, шинээр улс байгуулах, улс үндэстэн оршин тогтнох үндсийг бэхжүүлэх, үндэсний дархлааг бий болгоход чухал үүргийг гүйцэтгэжээ.

БНКаЗУ-ын тусгаар тогтнол, улс төр нийгэм эдийн эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтэй зэрэгцэн хэрэгжиж эхэлсэн шилжилт хөдөлгөөний бодлого нь шилжин ирэгчдэд тулгарсан саад бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна.

Энэ нь шилжин ирсэн олон тооны казах угсаатнууд шинэ газар нутагт дасан амьдрахад янз бүрийн бэрхшээлтэй тулгарсны улмаас засгийн газраас шинээр шилжин ирэгчдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд шилжилт хөдөлгөөний бодлогоо сайжруулсан байна.

1991 оноос эхэлсэн Монгол Улсаас казах иргэдийн шилжин явах үйл явц өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. 1990-ээд оны эхэн үед казах угсаатны шилжилт хөдөлгөөн нь улс орны эдийн засгийн хямралтай уялдан гарсан бөгөөд эхэн үедээ хүн амын шилжилт хөдөлгөөн нь “замбараагүй нүүдэл” байсан бол 2000 оноос хойш шилжин явагчид нь БНКаЗУ-ын талаархи өргөн ойлголттой болсонтой холбоотойгоор шилжих үйл явц нь “тодорхой зорилго, чиглэлтэй” болжээ. Сүүлийн жилүүдэд казах иргэдийн дунд БНКаЗУ-ын талаархи ойлголт сайжирч, шилжин очих хот суурин, ажлын байр, нийгмийн үйлчилгээг нь харгалзан шилжин явах хандлагатай байна. Мөн Монгол Улсаас хөдөлмөрийн насны залуучууд БНКаЗУ-д түр хугацаагаар ажиллаж, амьдрах үйл явц их байгаа бөгөөд тэдгээр түр ажиллахаар явагчид нь БНКаЗУ-ын иргэн харъяат болж, суурьшин үлдэх байдал ажиглагдаж байна.

Kazakhstan immigration policy impact for ethno-demographic structural changes

Amangul Shugatai

Research Fellow, MS

*Institute of International Affairs, Mongolian Academy of Sciences
Ulaanbaatar, Mongolia*

E-mail: amangulsh@mas.ac.mn

Abstract: *After the collapse of the Soviet Union, the Kazakhstan government implemented ethnic-based immigration policies which call for ethnic Kazakhs from abroad return to their historical homeland. In 1991, Kazakhstan started a repatriation process of calling back its ethnic Kazakh to belong to the new nation, and to their new found ethnic identity. The immigration policies has including the “repatriation process of ethnics”, have helped significantly as Kazakhs tries to reconcile past wrongs, increase internal stability and conserve national identity. Because of the Soviet era much of Kazakh language and traditional cultures was sufficiently reduced in the public sphere, and the ethnic composition in this country was dominated by non-titular ethnics. Thus, that ethnic immigration policy focused on change ethno-demographic structure of the Kazakhstan and increasing the total population size. This article focused to analyze the results of the ethnic immigration policy of Kazakhstan, how it has changed the immigration policy over the last 30 years.*

Key words: *Kazakhstan, migration policy, ethno-demographic changes, kazakh diaspora, ethnic kazakh migration process*

Ашигласан материал

1. Agentstvo Respubliki Kazakhstan po Statistiki, 2018. “Kazakstan Fsifrah 2008-2018, Statistichiskih Sbornik,” Astana, pp. 9-12, 850.
2. Barcus, Holly, and Werner, Cynthia, 2007. “Trans- National Identities: Mongolian Kazakh in the 21st Century,” Geographische Rundschau, International Edition, Vol.3, No.3, pp. 4-10.
3. Barcus, Shugatai 2018, “Immobile Populations as Anchors of Rural Ethnic Identity: Contemporary Kazakh Narratives of Place and Migration in Mongolia” Population, Journal, Space & Place Special Issue
4. Dave, Bhavna, and Sinnott, Peter, 2002. “Demographic and Language Politics in the 1999 Kazakhstan Census,” Watson Institute, Brown University, the National Council for Eurasian and East European Research. pp. 2.
5. Diener, Alexander, 2003. “One Homeland or Two: Territorialization of Identity and the Migration Decision of the Mongolian-Kazakh Diaspora,” Ph.D Dissertation, Madison: The University of Wisconsin, pp. 14, 140, 340.
6. Enbek, 2008/12. Postanovlenie Pravitelstva Respubliki Kazahstan ot 2 dekabrya 2008 goda, №1126, “Programma Nurly Kosh na 2009-2011 gody,” Ministerstvo Truda i Sosialnoi Zashity Naseleniya, Enbek Gov. KZ, <http://www.enbek.gov.kz/migration/migr_rusdetail.php?recordID=52&mintrud=1>
7. Government Program (Programma Pravitelystva), 2001.10.29. N1371. “Otraslevaya programma migratsionnoi politiki Respubliki Kazakstanna,” Astana. Zakondatelistvo Kazakstana,

8. <https://www.enbek.gov.kz/ru/node/345460> Об утверждении Концепции миграционной политики Республики Казахстан на 2017-2021 годы и Плана мероприятий по реализации Концепции миграционной политики Республики Казахстан на 2017-2021 годы
9. Kazakhstan, 1992. “Law on Migration”
10. Lee, Everett. S, 1966. “Theory of Migration,” Population of Association America, Demography, Vol.3, No.1, pp. 47-57.
11. Lewis A. W, 1954. “Economic Development with Unlimited Supplies of Labour,” Manchester School of Economic and Social Studies, Vol 22.
12. Mendikulova, Gulnara, 2005b.“Kazakskaya Diaspora i Irredenta: Istoriya i Soveremennosti,” Ethnoconfessiionninoe Prostranstvo Rossii, Electronnaya biblioteka, <<http://epr.phil.ru/store/web>>.,<<http://articles.excelion.ru/science/history/world/42462875.html>>.
13. Tatimov, Makash, 2005 “Kazaq Diasporasyngunung Ethnodemografiiasy Jane Egemen Kazakstan in Kazaq Diasporasy: Bugini Men Ertengi,” Astana, Elorda, pp. 8-10
14. UNDP, 2006. “Oralman of Status in Kazakhstan,” Overview, UNDP Kazakhstan, Almaty, pp. 4-15.
15. Werner, Cynthia and Barcus Holly, 2009. “Mobility and Immobility in a Transnational Context: Changing Views of Migration among the Kazakh Diaspora in Mongolia”, Migration Letter, Vol.6, No.1, pp. 49-62.
16. Yehuda Dominitz, “Israel’s Immigration Policy and the Dropout Phenomenon”, in Russia Jews on Three Continents: Migration and Resettlement, eds Noah Lewin-Epstein, Yaacov Ro’l and Paul Ritterband (London:Frank Cass, 1997) p.114
17. Казахстан- Монголия 20 жыл “Монгол:Найрсаг харилцаа хамтын ажиллагааны 20 жил” Улаанбаатар 2013.

18. Миграция 2017 Сентябрь 29, “Об утверждении Концепции 1.миграционной политики Республики Казахстан на 2017 - 2021 годы и Плана мероприятий по реализации Концепции миграционной политики Республики Казахстан на 2017 - 2021 годы” Постановление Правительства Республики Казахстан от 29 сентября 2017 года № 602
19. Монгол Улсын Үндэстний Статистикийн Хороо “Хүн ам орон сууцны тооллого” Нэгдсэн дүн, 1989, 2000, 2010, 2015 оны завсрын тооллого 2016:40, Улаанбаатар, 2016.